

**УЛААНБААТАР ХОТОД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ РАДИОГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ,
ШАЛГАЛТЫН ТАЙЛАН- 2023 он.**

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 04-р сарын 10-ны өдрийн А/106 тоот “Хяналт шалгалт хийх тухай” тушаал, удирдамжийн дагуу Улаанбаатар хотод арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн Зохицуулах хорооноос баталсан нөхцөл, шаардлага, журмын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг газар дээр нь шалгаж, шалгалтын үр дүнгийн дагуу арга хэмжээ авч ажиллав.

1. Шалгалт хийгдсэн хугацаа:

2023 оны 04 дүгээр сарын 25-аас 05 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд шалгалтыг хийж гүйцэтгэв.

2. Шалгалтын ажлын хэсгийн гишүүд:

Ажлын хэсэг нь Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын дарга Э.Золбаяр, Зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн дарга Н.Тогтохсүрэн, хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Машбат, мэргэжилтэн М.Эрдэнэцэцэг, Д.Уранбилэг, О.Билгүүн, Радио давтамж хяналт зохицуулалтын газрын мэргэжилтэн П.Гэрэлтцэцэг, инженер Б.Болдбат, Ц.Өсөхбаяр. Д.Ганбат, М.Чагнаадорж, М.Энхзориг нарын бүрэлдэхүүнтэй ажилласан.

3. Шалгалтанд хамрагдсан үйлчилгээ эрхлэгчид:

Улаанбаатар хотод арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгч 33 радиогоос 31 радиогийн үйлчилгээ эрхлэгчид хамрагдсан байна.

Тусгай зөвшөөрлийн ангилал: Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Үйлчилгээний нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дуусах огноо	Байршил
1	РФ ХХК	kiss radio FM 100.1	12800003	2027.01.14	Улаанбаатар хот
2	Салхи Энтертэймэнт ХХК	Гэр бүлийн радио FM-104.5	12800006	2028.05.05	Улаанбаатар хот, Улаанбаатар. Налайх дүүрэг, 21 аймгийн нутаг дэвсгэрт
3	Медиа холдинг ХХК	Тэнгэрлэг радио FM-103.6	12800008	2027.04.26	Улаанбаатар хот

4	Стандарт Ви Оү Эй ХХК	Америкийн дуу хоолой FM-106.6	12800016	2026.02.25	Улаанбаатар хот
5	Билэг санаа ХХК	Шинэ долгион FM-107.5	12800017	2024.04.12	Улаанбаатар хот
6	Чугу ХХК	VIBE FM 105.5	12800019	2024.01.01	Улаанбаатар хот
7	НС Холбоо ХХК	Гийнгоо FM 100.5	12800018	2027.10.12	Улаанбаатар хот
8	Нью медиа ХХК	Инээмсэглэл FM-99.3	12800025	2027.07.20	Улаанбаатар хот
9	Монголиан Мюзик Медиа ХХК	Бизнес радио FM 98.9	12800024	2027.07.20	Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхонаймгийн нутаг дэвсгэрт
10	Радиоком Монгол ХХК	Формула FM 98.1	12800026	2027.07.20	Улаанбаатар хот
11	Ви Өү Эм ХХК	Эрүүл амьдралын радио FM-104	12800027	2024.01.31	Улаанбаатар хот
12	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо ГҮТББ	Best FM-98.5	12800030	2021.12.24	Улаанбаатар хот
13	И Зэт Эф Эм ХХК	Эх дэлхий FM-107.0	12800042	2024.01.31	Улаанбаатар хот
14	Бадруун ХХК	Радио УБ FM-102.5	12800050	2024.01.01	Улаанбаатар хот
15	Дижитал радио ХХК	Их Монгол FM-99.7	12800062	2027.01.10	Улаанбаатар хот
16	Монголын бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийд ШБ	Лавайн эгшиг FM-97.5	12800073	2027.11.14	Улаанбаатар хот, 21 аймгийн нутаг дэвсгэрт
17	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМБ	Авто радио FM 96.3	12800076	2024.12.10	Улаанбаатар хот
18	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан НҮТББ	Арга билиг FM 95.7	12800092	2028.04.20	Улаанбаатар хот
19	Шүхэр НҮТББ	Хамаг Монгол FM-95.1	12800111	2023.10.01	Улаанбаатар хот
20	Эх элгэн нутаг ХХК	Элгэн нутаг FM-96.9	12800130	2027.11.01	Улаанбаатар хот
21	Хэмнэлт долгион медиа групп ХХК	Хэмнэл радио FM-91.7	12800136	2027.03.23	Улаанбаатар хот
22	Тэргүүн медиа ХХК	Стар FM 92.5	12800139	2025.03.23	Улаанбаатар хот
23	Агрегатор ХХК	Тэргүүлэгч FM-101.7	12800146	2028.05.25	Улаанбаатар хот

24	Монгол комикс ХХК	Цаг үе залуус FM-91.1	12800149	2027.06.20	Улаанбаатар хот
25	Смарт коммуникэйшн ХХК	Тойм FM-92.1	12800148	2027.06.20	Улаанбаатар хот
26	СКОД ХХК	Medeemn FM-88.8	12800158	2024.02.21	Улаанбаатар хот
27	Эм Эс Жи Эм Эл ХХК	Монголчуудын радио FM 102.1	12800165	2028.01.14	Улаанбаатар хот
28	Улаанбаатар телевиз ХХК	VIP радио 90.5	12800168	2028.05.01	Улаанбаатар хот
29	Жавзандамба хутагт төв НҮТББ	Зохист аялгуу FM-89.7	12800180	2024.05.25	Улаанбаатар хот
30	Эм Жи Эл Радио ньюс ХХК	Эм Жи Эл Радио Ньюс FM 88.3	12800186	2025.08.30	Улаанбаатар хот, 21 аймгийн төв
31	Сета тех ХХК	Аялгуу FM 89.3	12800187	2025.08.30	Улаанбаатар хот

Хяналт, шалгалтанд нийт 33 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс дараах 2 радио үйл ажиллагаа явуулахгүй байгаа тул шалгалтанд 31 радио хамрагдсан. Үүнд:

1. Монкаст радио ХХК нь үйл ажиллагаагаа явуулахгүй байгаа, тодорхойгүй хугацаагаар хөтөлбөр дамжуулалтаа зогсоосон нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 31.3.3, Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу эфирин тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах үүргийн хэрэгжилт хангалтгүй тул Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээ авах нөхцөл байдал үүссэн;
2. ШУТИС-ын 94.1 радио нь 2022 оны 05 дугаар сараас хойш тодорхойгүй хугацаагаар хөтөлбөр дамжуулалтаа зогсоосон, үйл ажиллагаа явуулаагүй байсан тул шалгалтанд хамрагдаагүй.

4. Шалгалтын зорилго:

4.1 Холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг шалгах

4.2 Үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг газар дээр нь шалгах.

4.3 Илэрсэн зөрчлийг таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээг авах

4.4 Үүсч буй хүндрэл бэрхшээл, асуудлыг сонсох, судлах, зөвөлгөө өгөх.

4.5 Шалгалтын дүнд үндэслэн арга хэмжээ авах.

5. Шалгалт хийсэн чиглэл:

- 5.1. Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг шалгах:

Бичиг баримтын бүрдэл, хууль тогтоомж, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад заасан дүрэм журам, баримт бичгийн бүрдэл, хүний нөөц, санхүү, техникийн чадавх, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдал тухайлбал: эзэмшлийн мэдээлэл, статистик тайлан мэдээ хугацаанд нь ирүүлсэн байдал, тусгай зөвшөөрлийн төлбөр, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн байдал;

- 5.2. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23, 24, 30.1.7 зүйл заалтуудын / Хөтөлбөрт тавигдах шаардлага хангасан байдал буюу Үндэсний бүтээл, Монгол дуу, Өөрийн бүтээл, Хөтлөлттэй, шууд нэвтрүүлэг, Үндэсний түүх, соёл, уламжлал, хүүхэд танин мэдэхүйн нэвтрүүлэг, Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны журмын хэрэгжилт, /хэрэгжилтийг радиогийн хяналт, мониторингийн тайланг хянан үзэх/
- 5.3. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 21.2 зүйлд заасан студийн техник, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, холболт, стандартын хэрэгжилт, мөрдөлт, аюулгүй ажиллагааг мөрдөж байгаа эсэх;
- 5.4. Радио долгионы ашиглалтын байдал: Радио долгионы тухай хуулийн 19 дүгээр зүйл болон тус Хорооны 2022 оны 38 тоот тогтоолоор батлагдсан “Хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлэгт ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл шаардлага” болон радио давтамжийн тусгай зөвшөөрлийн гэрээний хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийсэн.

6. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

Rohde and Schwarz FSH8 Spectrum analyzer зөөврийн хэмжүүрийн төхөөрөмж, R&S HE300 9 КГц – 7.5 ГГц давтамжийн зурваст хэмжих антенны ком, smart field meter болон өргөн нэвтрүүлгийн дуу, дүрсийн гаралтын чанарт WFM 2300 tektronix хэмжүүрүүдийг тус тус ашиглав. Уг хяналт шалгалтад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бие төлөөлөгч нар хамтран ажилласан.

7. Шалгалтын дүгнэлт

Шалгалтын явцад дараах нөхцөл байдал ажиглагдаж байсан. Үүнд:

- Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд зарим нь сонсогдолтын байдлаас болж зар сурталчилгаа авч чадахаа больсон, зогсонги байдалтай;
- Зарим радио идэвхгүй, хуучин нэвтрүүлэг, эфирт дуу өрсөн байдалтай, хариуцсан эзэн байхгүй;
- Орлогоос хамаарч үйл ажиллагаагаа сайжруулах идэвхи муутай;
- Үйл ажиллагаа явуулж байгаа боловч статистик тайланг Х тайлангаар өгдөг
- Тохирлын гэрчилгээтэй нэвтрүүлэгч ашигладаггүй, гар хийцийн нэвтрүүлэгч ашигласнаас болоод давтамжийн хазайлт, зурвасын өргөн үүсгэдэг;
- Дууны түвшиний хазайлт өндөр, шалтгаан нь:

- Студийн тоног төхөөрөмжийн холболт буруу хигдсэн;
- Тоног төхөөрөмжийн буруу тохиргоо хийсэн;
- Зориулалтын бус кабель ашигласан зэрэг нөхцөл байдлууд тогтоогдсон.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЕХНИК, СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙДАЛ


- Аливаа гэмтэл саатал гарсан тохиолдолд тоног төхөөрөмжийн араар нь орж засвар үйлчилгээ хийх боломжгүй суурилуулалтийг хийсэн.
- Нэвтрүүлгийг хэвийн, сааталгүй дамжуулах үүднээс үндсэн болон нөөц горимд шилжин ажиллах техникийн боломжгүй.
- Радиогийн бичлэгийн студи, эфирийн хяналтын өрөө тусдаа байх стандарттай ч зарим радио нэг өрөөнд хамтад нь байрлуулсан.
- Тоног төхөөрөмжийн холболтын кабелийн хаягжилт, сувагчлал, газардуулга хийгдээгүй;
- Дууны гаралтын чанар болон түвшиндээ хяналт тавьж ажилладаггүй, дууны хяналтын систем байхгүй.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО


ТЕХНИК, СТАНДАРТЫН ШААРДЛАГА ХАНГАСАН БАЙДАЛ

Playout-ийн програм хангамж



80 % нь шаардлага хангасан
(сонсогдолтоос хамаарч зар сурталчилгаа буурсан)

Радиогийн студийн дуу чимээнээс хамгаалах түвшин





ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЕХНИК СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Өөрсдийн дуу оруулалтын цэг болон монтаж хийхдээ (adobe audition) дууны дохионы түвшинг өөрсдийн сонсголын түвшингээр тохируулж байна.






Үйлчилгээ эрхлэгчдийн дууны холигчийн гаралтан дахь хэмжигдэхүүнүүд (dBu, dBFS, dB гм)тавигдсан байдгаас PML, PPM, AL зэрэг дууны өөр өөр утгатай хэмжигдэхүүнүүдийг хэмждэг нь үйлчилгээ эрхлэгчид яг ямар түвшин барихаа мэдэхгүй байна.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ДУУНЫ ТҮВШИННИЙ ХЭМЖИЛТИЙН БАЙДАЛ




Студийн дууны гаралтын түвшинг WFM Tektronix 2300 төхөөрөмжөөр давтамжийн хазайлттай зэрэгцүүлэн хазайлтыг багасгах зорилгоор хэмжилтийг хийсэн.

Дараах шалтгаануудын улмаас дууны түвшин харилцан адилгүй, студийн дууны гаралтын түвшин нь бага хирнээ давтамжийн хазайлт өндөр байна. Үүнд:



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОЛБОЛТ, ТОХИРГОО



Дууны холигчийн өсгөлт (gain)-ийг хэт нээх эсхүл хаах;

Дууны ерөнхий гаралтыг компьютерийн чихэвчний гаралтаас дууны холигчийн шугаман бус оролтод өгсөн;

Дууг L эсхүл R буюу нэг замаар холбосон, инженер техникийн ажилтан байхгүй.

Audio compressor буюу дууны хязгаарлагчийн гаралтыг буруу тохируулсан;




ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ХҮНИЙ НӨӨЦ



Хүний нөөц



Радио нь **0-18** ажилтантай, нийт 30 радиогоос хөдөлмөрийн гэрээтэй, НДШ төлдөг-63%, ИТА-гүй 70% байна.

Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага хангасан байдлын тухайд радиоогийн үйлчилгээ эрхлэгчдийн 2022 оны хяналт, мониторингд хамрагдсан дүн мэдээ болон 2023 онд мониторингд хамрагдсан байдлыг авч үзсэн. Хяналт, мониторингийн тайлан Зохицуулах хорооны цахим хуудсанд ил тод байршуулдаг тул энэ тайланд дэлгэрэнгүй давтан оруулсангүй. Радиоогийн хөтөлбөрийн шаардлагын хувьд 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50 %-иас доошгүй нь үндэсний буюу Монгол бүтээл байх шаардлага бүх радио хангасан, 7 хоногийн хөтөлбөрт эзлэх нийт дууны 25 %-иас доошгүй нь Монгол дуу байх шаардлагын тухайд 1 радиогоос бусад нь шаардлага хангасан. Тухайн 1 радиоогийн хувьд хөтөлбөрийн онцлог нь төрөлжсөн, дуу нэвтрүүлдэггүй, бизнес, эдийн засгийн төрөл бүрийн нэвтрүүлэг бэлтгэн хүргэдэг цөөн цагт классик дуу нэвтрүүлдэг онцлогтой байна. Гэвч тус радиод нөхцөл шаардлага хангах шаардлагатай талаар зөвлөмж өгч ажиллав. Өөрийн бүтээл нэвтрүүлэг нь 30%-иас хэтрэхгүй байх шаардлагын тухайд 8 FM шаардлага хангасан, 7 хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 15 %-иас багагүй

нь хөтлөлттэй шууд нэвтрүүлэг байх шаардлагыг 14 радио хангаж ажилласан байна. Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд жилд нэвтрүүлэх үндэсний түүх соёл, уламжлал, хүүхэд танин мэдэхүйн нэвтрүүлэг 360 цагаас багагүй байх шаардлага тавьдаг бөгөөд улиралд 90 цагаас илүү, шаардлага хангахуйц цагаар нэвтрүүлсэн 20 радио байна. Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны журмын тухайд 1 цагт 18 минутаас хэтрэхгүй байх шаардлагыг 80 %-д нь хангасан, сонсогдолтын байдлаас хамаарч зар сурталчилгаа буурсан, зар сурталчилгаа багатай байгаа тул зар сурталчилгааны хэтрэлийн зөрчил бага байлаа. Харин зар сурталчилгааны 1 блокийн үргэлжлэх хугацаа 3 минутаас хэтрэхгүй байх шаардлага хангалтгүй байв. Тус зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд 2 жил болж байгаа, өнгөрсөн хугацаанд зөвлөмж мэдээлэл өгч ажилласан боловч зарим радиогийн хувьд хариуцсан ажилтан солигдсон, энэ талаарх ойлголт дутмаг байгаагаас гадна блокийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх хүсэлт тавьж байлаа. Хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээр ялангуяа өөрийн бүтээл, хөтлөлттэй шууд нэвтрүүлгийн шаардлага хангахгүй, үндэсний түүх, соёл, хүүхдийн нэвтрүүлгийн шаардлага хангахгүй байгаа радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд арга хэмжээ авч ажиллалаа.

Радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс өгсөн тайлбар, гомдол саналын тухайд:

- Япон машинд сонсогдолгүй байдлаас болж орлого олохоо больсон, зар сурталчилгаа авах гэхээр ямар машинд сонсогдохыг асуугаад гэрээ байгуулахаа больсон, ялгаж радионуудад өгдөг байдлаас болж зар сурталчилгаа авч чадахаа больсон, мэргэжлийн боловсон хүчин ажиллуулах, байрны түрээс зэрэг зардлаа төлөх боломжгүй байна;
- Нэвтрүүлэг бэлтгэх хүний нөөцийг цалинжуулах орлого байхгүй.
- Давтамжийн хуваарилалтыг хүлээсэн байдалтай
- Хүний нөөц дутмаг, радиогийн инженер бэлтгэгддэггүй,

Цаашид авах арга хэмжээний саналаар 13 радиогийн үйлчилгээ эрхлэгчид техникийн зөвлөмж өгөх, 18 радиогийн үйлчилгээ эрхлэгчид хугацаатай үүрэг даалгавар өгөх, 9 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг гаргасан.

8. Шалгалтаар хийж гүйцэтгэсэн ажлууд:

Уг шалгалтаар Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/106 тоот тушаалаар баталсан удирдамжийн Улаанбаатар хотын арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн биелэлтэд холбогдох хууль, тус хорооноос батлан гаргасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагууд болон техник, стандартын хэрэгжилтийн байдлыг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Шалгалтыг “Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалт хийх тухай, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг бэлтгэсэн байхыг урьдчилан мэдэгдсэн.

Шалгалтад хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гаргаж, зарим үйлчилгээ эрхлэгчдэд буюу үйл ажиллагаагаа нь тогтворгүй, мониторингийн дүнгээр хангалттай бус байгаа үйлчилгээ эрхлэгчдэд гаргасан зөрчил тус бүрээр хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелэлтийн тайланг нотлох баримтаар баталгаажуулан авахаар төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн шалгалтад хамрагдсан нийт үйлчилгээ эрхлэгчдэд мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч хууль, журам, нөхцөл шаардлагын талаар сургалт зохион байгуулж, үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлын талаар харилцан ярилцлага өрнүүлж, санал солилцож ажилласан.

9. Хяналт, шалгалтын ажлын үр дүн:

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/106 тоот тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйлажиллагаа эрхэлж байгаа радиогийн үйлчилгээ эрхлэгчдэд хяналт, шалгалтыг хийж үйлчилгээ эрхлэгч тус бүрээр тайланг боловсруулж, аргачлалын дагуу үнэлэлт, дүгнэлтийг хийсэн.

Хяналт шалгалтын дэлгэрэнгүй тайлан мэдээллийг Харилцаа холбооны зохицуулах хорооны Даргын зөвлөлийн 2023 оны ээлжит 6-р хуралдаан, Хорооны хуралдаанд танилцуулж, нийт 9 үйлчилгээ эрхлэгчдэд түдгэлзүүлэх сонсох ажиллагаа хийсэн ба сонсох ажиллагааны үр дүнд ирүүлсэн тайлбар мэдээллийг үндэслэн дараах тусгай зөвшөөрөл эзэмшигчид хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн. Үүнд:

д/д	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Радиогийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	РФ ХХК	kiss radio FM 100.1	12800003
2	Нью медиа ХХК	Инээмсэглэл FM-99.3	12800025
3	Хүүхэд ирээдүй соёл боловсрол сан НҮТББ	Арга билиг FM 95.7	12800092
4	Медиахолдинг ХХК	Тэнгэрлэг радио FM-103.6	12800008
5	Радиоком Монгол ХХК	Формула FM 98.1	12800026
6	Дижитал радио ХХК	Их Монгол FM-99.7	12800062

Дараах 3 үйлчилгээ эрхлэгчдэд түдгэлзүүлэх арга хэмжээ авсан. Үүнд:

д/д	Тусгай зөвшөөрөл	Радиогийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тайлбар
-----	------------------	---------------	---------------------------	---------

	ЭЗЭМШИГЧИЙН НЭР			
1	Шүхэр НҮТББ	Хамаг Монгол FM-95.1	12800111	2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 91 тоот тогтоолоор 45 хүртэлх хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн.
2	И Зэт эф эм ХХК	Эх дэлхий FM- 107.0	12800042	2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 91 тоот тогтоолоор 45 хүртэлх хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн.
3	Улаанбаатар телевиз ХХК	VIP радио 90.5	12800168	2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 91 тоот тогтоолоор 45 хүртэлх хоногийн хугацаагаар түдгэлзүүлсэн.

Дээрх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн 3 радиогийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгаварын биелэлт, үүрэг даалгаварын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын талаарх тайлан, нотолгоог үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 9-р сарын 28-ны өдрийн 117 тоот тогтоолоор Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар
Харилцаа холбооны зохицуулах хороо